

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 20

1.	<i>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/</i>	5 – 10
2.	<i>Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан</i>	10 – 20

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 04 дүгээр сарын 30-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 58 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Пүрэвдорж;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Б.Баярбаатар, Б.Батбаатар, Ө.Шижир, Т.Доржханд, Л.Оюун-Эрдэнэ, Н.Номтойбаяр, Л.Гантөмөр, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт
/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Байнгын хороодын ажлын албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт “Тойрогт ногдсон мандатын тооноос ... дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн ... саналын хуудсыг хүчингүйд тооцно.” гэж заасны “... дутуу ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд ... чөлөөтэй ... сонгох эрхийн үндсэн дээр ... сонгоно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 13

Бүгд: 14

7.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны Мониторингийн газрын дарга Д.Үүрийнтуяа, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны референт Ш.Бумаажав, ахлах шинжээч Б.Отгонцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Байнгын хороодын ажлын албаны референт Б.Баярсайхан, Үнэлгээ, мониторингийн газрын дарга Б.Алтантуяа, зөвлөх Б.Отгонсүрэн, референт А.Амармэнд нар байлцав.

Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Баярмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны Мониторингийн газрын дарга Д.Үүрийнтуяа нар хариулж, тайлбар хийв.

Тайлангийн хэлэлцүүлгийг хойшлуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 37 минутад хэлэлцэв.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 40 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 38 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 58 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн ирцийг танилцуулъя.

Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн, Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн, Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн ирсэн, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн, Энхбатын Болормаа гишүүн ирсэн, Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн, Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц бүрдсэн тул Байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох зохицуулалт, Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх.

Хоёр.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан гэсэн ийм хоёр асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт
/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн
72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт
Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 84.2.1-д цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол долоо хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж, бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь хэсэгчлэн хүлээн авах, зөвшөөрөх, эс зөвшөөрөх асуудлаас санал, дүгнэлт гаргана гэж заасан байгаа.

Энэ дагуу Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж байна.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа.

Ингээд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг хийнэ.

Г.Уянгахишиг гишүүний микрофоныг нээе.

Г.Уянгахишиг: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийн агуулгын талаар танилцуулга хийе.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн дунд суудлын хуралдаанаар иргэн Н.Туяагийн гаргасан мэдээллээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт “тойрогт ногдсон мандатын тооноос илүү, эсвэл дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн нам, эвслийн санал тэмдэглэх хэсэгт нэгээс илүү нам эвсэл санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.” гэж заасныг “тойрогт ногдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.” гэсэн нь Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд чөлөөтэй сонгох эрхийн үндсэн дээр сонгоно гэснийг зөрчсөн эсэхийг хянан хэлэлцсэн.

Уг хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72.1-д заасан мандатын тооноос дутуу тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцож байгаа нь Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасан байна.

Үндсэн хуулийн цэцэд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг миний бие томилогдон хариу тайлбартаа Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг нь сонгогчдод сонголт хийх боломжтой хувилбарыг санал болгож, сонгогч, тэдгээрээс өөрийн хүсэл зоригоор хэн нэгний хөндлөнгийн оролцоонд нөлөөлөлгүйгээр чөлөөт сонголт хийх боломж бөгөөд чөлөөт сонгуулийн үндсэн зарчим нь хууль зүйн утгаараа иргэн сонгуульд заавал оролцох үүрэг хариуцлага хүлээхгүй байх явдал бөгөөд сонгогч саналаа өгөх үед нөлөөлөх, албадах, хүчээр өөрийнх нь сонгохыг хүсээгүй хүнийг нэр заан тулгаж, түүний төлөө санал өгүүлэхэд сонгогчийг хамгаалахад чиглэдэг гэсэн агуулгыг онцолсон.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72.1 дэх хэсэг нь сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгуульд оролцох, эс оролцохыг албадсан, эсвэл хориглосон аливаа агуулгагүй бөгөөд хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлж, сонголт хийхэд нь нөлөөлөх утга илэрхийлээгүй гэж үзэж байгааг мөн тайлбарласан.

Түүнчлэн Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.” гэж заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт “мандатын тооноос илүү, эсвэл дутуу” гэсэн нь сонгуульд сонгогч сонгуульд чөлөөтэй сонгох эрхээ эдлэхэд анхаарах арга зүйн асуудлыг хуульчилсан зохицуулалт юм.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэлд маргаан бүхий зохицуулалт нь сонгогч тойрогт ногдох мандатын тооноос цөөн нэр дэвшигчийг дэмжих сонголтоо хэрэгжүүлэхийн тулд мандатын тоотой тэнцүүлж санал өгөх, улмаар өөрийн дэмжихгүй нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэхээс өөр аргагүйд хүргэхээр байна гэдгийг дурдсан бөгөөд өөрөөр хэлбэл сонгогч нэр дэвшигчийн талаар чөлөөт сонголт хийх саналаа тэмдэглэх боломжийг хязгаарлаж байна гэж үзсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.10 дахь хэсэгт сонгогч нэг ч нэр дэвшигч, эсвэл нам эвслийн төлөө санал өгөөгүй бол хэнийг ч дэмжээгүй санал гэж үзэн тухайн сонгогчийг санал өгсөн сонгогчдын тоонд оруулан тоолж, уг саналын хуудсыг хүчинтэйд тооцож байгаа мөртлөө 72.1 дэх хэсэгт мандатын тооноос дутуу нэр дэвшигчийг тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцож байгаа нь эдгээр хоёр ойлголт нь холбогдох нэр дэвшигч, эсвэл нам, эвслийг дэмжихгүй гэсэн сонгогчийн

сонголтыг илэрхийлэх утгаараа төстэй байтал нэгийг нь хүчинтэйд тооцож, нөгөөг нь хүчингүйд тооцож байгааг хуулийн зохицуулалт хооронд зарчмын хувьд зөрчил үүсгэж, сонгогчийг төөрөгдөлд оруулж байна гэж үзжээ.

Цэцийн дүгнэлтийн үндэслэлд сонгогч тухайн саналын хуудаст байгаа нэр дэвшигчдээс өөрийг нь төлөөлж чадна гэсэн итгэлийг хэнд хүлээлгэхээ бие даан шийдсэний үндсэн дээр саналаа чөлөөтэй өгөх эрхтэйг дурдсан.

Цэцийн дүгнэлтэд Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан чөлөөтэй сонгох зарчим нь сонгогч, нэр дэвшигч, нам, эвслийг дэмжих, эсвэл дэмжихгүй байх сонголтоо албадлага, дарамт, сүрдүүлэг, эсвэл гаднын зүй бус нөлөөлөлгүйгээр өөрийн итгэл үнэмшил, үзэл бодлын дагуу хийж саналын хуудас тэмдэглэх агуулгатай.

Иймээс сонгогч нэр дэвшигч нараа сонгохдоо тухайн тойрогт ногдсон мандатын тооноос илүү санал тэмдэглэж болохгүй ч хэнийг ч дэмжсэн санал өгөөгүй байх. Мөн өөрийн дэмжсэн нэр дэвшигчийн тоо тухайн тойрогт ногдсон мандатын тооноос цөөн байвал уг мандатын тооноос дутуу хэмжээгээр зөвхөн өөрийн дэмжсэн нэр дэвшигчийн төлөө саналаа тэмдэглэх эрхтэй байна гэсэн байна.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Цэцэд Г.Уянгахишиг гишүүн маань төлөөлөгчөөр очиж хуралд оролцсон. Тийм болохоор одоо сая танилцуулгыг уншлаа. Танилцуулгыг хийлээ.

Ингээд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү. С.Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Үндсэн хуулийн цэцэд тодорхой хуулийн зохицуулалт, заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх талаарх маргаан сүүлийн үед тодорхой иргэдээс, тодорхой субъектээс гардаг болсон. Энэ бол нэг талдаа сайн гэж ойлгож байгаа.

Иргэдийн эрх зүйн боловсрол, улс төрийн улс төрийн боловсрол сайжирч байгаа хэлбэр байх.

Нөгөөтээгүүр Үндсэн хуулийн цэц ч гэсэн энэ асуудлыг ихэнх тохиолдолд онолынхоо талаас нь, арга зүйн талаас нь, хүний эрх талаас нь маш нарийн үнэлэлт дүгнэлт өгч шийдвэр гаргаж байгаа байх. Энд эргэлзэх зүйл алга.

Яг өнөөдрийн Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлттэй холбогдуулаад би хоёр санал хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт, танилцуулгатай холбоотойгоор бид энд тодорхой шийдвэр гаргана. Өөрөөр хэлбэл цэцийн шийдвэрийг хүлээж авах эсэх талаар шийдвэр гаргана шүү дээ.

Яг энэ асуудал одоо энэ хууль хэлэлцэх гэж байх үед, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль хэлэлцэх гэж байх үед энэ асуудлыг хэрхэн авч үзэж байсан юм бэ гэдэг хурлын протоколтой ер нь танилцаж баймаар юм шиг байгаа юм. Бидэнд тэр хурлын протокол байвал тэндээс бид энэ ойлголтоо бүрэн авч байж бид одоо эндээс гарах шийдвэрт илүү рационал, илүү тодорхой оролцох боломж гаргах байх гэсэн ийм нэгдүгээр санал байна.

Хоёр дахь зүйл, энэ чөлөөтэй сонгох, сонголт хийх эрхэд нь нөлөөлсөн. Түүнээс гадна чөлөөтэй сонгох эрхийг нь хязгаарласан байна гэж үзэж байгаа юм. Үзсэн байна л даа. Гэтэл чөлөөтэй сонголт гэдэг юу вэ гэдгийг бид ном, сурах бичгээс, эрдэм шинжилгээний нийтлэлүүдээс авч уншлаа. Чөлөөтэй сонголт гэдэг бол хоёр болон түүнээс дээш хувилбараар сонголт хийх боломжийг нэгдүгээрт илэрхийлнэ гэсэн байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тодорхой ямар нэгэн субъектийн нөлөөгүйгээр, дарамт шахалтгүйгээр сонголт хийх тэр эрхийг хэлнэ гэсэн байгаа юм.

Тэгэхээр одоо яг саяын зохицуулалт бол аваад үзэх юм бол тэртээ тэргүй тэр хоёроос дээш сонголт олгосон юм чинь чөлөөтэй сонгох тэр боломжийг нь олгочихсон байна гэж үзэхээр байгаа байхгүй юу. Нэгдүгээр үндэслэлээр нь.

Хоёрдугаарт, энэ ямар нэгэн дарамт шахалт гэхээсээ илүүтэйгээр тэр төлөөллийн байгууллагаа сонгохын тулд, төлөөлөл бүрэн байхын тулд энэ сонголтыг та хийх үүргээ хэрэгжүүлээч ээ гэсэн ийм зохицуулалт байна гэж ойлгож байгаа юм.

Тэгэхээр энэ үүднээс нь аваад үзэх юм бол Үндсэн хуулийн энэ дүгнэлтийг бид нарийн хэлэлцэж байж шийдвэр гаргах ёстой юм байна гэсэн ийм бодолтойтой байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд ганц хоёр зүйл хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Цэцийн дүгнэлтийг хувь гишүүнийхээ хувьд хүлээж авах боломжгүй гэж харж байгаа.

Сая С.Зулпхар гишүүний хэлсэнчлэн бид төлөөллийн бүрэн бүтэн төлөөлөл байх, жигд төлөөлөлтэй байх, төрийн байгуулалт маань ард

иргэдээсээ сонгогдсон бүтэн төлөөллийг бий болгосон ийм Улсын Их Хурал бүрэлдэх ёстой, парламент бүрэлдэх ёстой гэдэг өнцгөөсөө хууль тогтоогчид маань харах нь зүйтэй байх гэж харж байгаа.

Хэрвээ бид үүнийг хүлээгээд авах юм бол чөлөөт сонголт гэдгийн ар тал дээр зарим нэгэн тойргийн төлөөлөл хаягдах магадлал байна гэж миний хувьд харж байгаа.

Өөрөөр хэлбэл бид бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаа хүлээж аваад Монгол Улс бүсчилсэн байдлаар хөгжих нөхцөл байдлыг бий болгосон. Ингээд нэг тойрог дээрээ 3-аас 4 аймаг харьяалагдаж байгаа.

Тэгээд энэ хүрээнд бас тодорхой онцлог бий. Зарим аймгууд оршин суугчдынхаа хувьд төвлөрөл нь илүү болсон. Иргэдийн хувьд арай илүү иргэдийн төвлөрөл нэг талдаа гарсан байх жишээтэй.

Тэгэхээр бид үүнийгээ жигд болгохын тулд бүсчилсэн байдлаар хөгжье гэсэн энэ том онолыг гаргаж байсан шүү дээ.

Тэгэхээр үүнтэй уялдаад магадгүй хэрвээ энэ байдлаар цэцийн дүгнэлтийг хүлээж аваад явах юм бол магадгүй зарим нэг аймаг дээр, өөрөөр хэлбэл төвлөрөл багатай ийм аймаг дээр төлөөлөлгүй болох нөхцөл бас бий болох байдал харагдаад байгаа юм.

Нөгөө талаар бид шударга сонголтыг явуулах нөхцөл байдлыг төр бий болгох ёстой. Өөрөөр хэлбэл сонгуулийн тухай хуульдаа үүнийг зайлшгүй оруулах ёстой. Тэгээд тэр утгаараа магадгүй бид зарим нэгэн асуудлыг хөндөж харах нь зүйтэй байх гэж бодож байна. Санал худалдаж авахтай холбоотой асуудлууд. Нөгөө амьдрал дээр гараад байдаг царцааны нүүдэл гэх мэтчилэн ийм асуудлуудыг хаах боох энэ асуудлыг бас бодолцохгүй бол магадгүй тодорхой хүрээнд ажиллаад, тодорхой ийм хууль бус үйлдлүүдийг хийгээд тэгээд эндээсээ тухайн иргэн илүү саналын эрх авах, илүү санал авах ийм нөхцөл байдал. Өөрөөр хэлбэл тэгш бус санал авах нөхцөл байдал бас бий болох байх гэсэн нэг ийм байдал харагдаад байгаа юм.

Тийм болохоор С.Зулпхар гишүүнтэй санал нэг байна. Үүнийг ер нь цаашдаа дахиад нэг Байнгын хороон дээрээ сайн үзэх хэрэгтэй байх. Хэлэлцэж байх үеийн протоколыг бас харах хэрэгтэй байх.

Тэгээд дээрээс нь ер нь гишүүд маань дахин нэг сайн үндэслэлийг харах нь зүйтэй байх гэж бодож байгаа юм.

Тийм болохоор дараагийн Байнгын хороон дээр энэ саналыг харж үзэж дахин нэг тойрч сууж байж хуралдаж энэ талаар дүгнэлт дээр үндэслэлүүдийг нь бас нэг үзэх нь зүйтэй байх л гэж харж байгаа юм шүү.

Ингээд санал хураалт. Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Ингээд санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт “Тойрогт ногдсон мандатын тооноос ... дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн ... саналын хуудсыг хүчингүйд тооцно.” гэж заасны “... дутуу ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд ... чөлөөтэй ... сонгох эрхийн үндсэн дээр ... сонгоно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 14 гишүүн оролцож, 1 гишүүн зөвшөөрч, 13 гишүүн татгалзаж, санал дэмжигдсэнгүй.

Ингээд санал, дүгнэлтийг Э.Болормаа гишүүн танилцуулах уу? Санал, дүгнэлтийг чуулганд Э.Болормаа гишүүн танилцуулъя.

Ер нь үүнийг бас сайн үзэх нь зүйтэй байх гэж бодож байгаа. Тийм. Сая гишүүдийн гарсан санал ч байна. Буцаж эргэж хараад хэдүүлээ дараагийн Төрийн байгуулалтын байнгын хороогоор хууль зүйн талынх нь үндэслэлийг бас нэг ярилцах нь зүйтэй байх гэж үзэж байна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Хоёр.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон
Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн
тайлан**

Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйл Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэх.

16.1.Улсын Их Хурлаас Засгийн газар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон, энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ.

16.2.Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ирүүлснээс хойш 15 хоногийн дотор Тамгын газар Байнгын хорооны эрхлэх асуудал бүрээр дүн шинжилгээ хийж, танилцуулгын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

16.3.Байнгын хороо Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг энэ хуулийн 16.2-т заасан танилцуулгыг хүлээн авснаас хойш нэг сарын дотор хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцэж байгаа.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан албан тушаалтнуудыг танилцуулъя. Урьж оролцуулаарай.

Э.Одбаяр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга, Д.Үүрийнтуяа Засгийн газрын Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны Мониторингийн газрын дарга, Ш.Бумаажав Засгийн газрын Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны референт, Б.Отгонцэцэг Засгийн газрын Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны ахлах шинжээч.

Эдгээр хүмүүсийг оруулъя.

Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн танилцуулгыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр хийнэ.

Э.Одбаяр сайдын 6 номерын микрофоныг нээе.

Э.Одбаяр: Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-д хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлан, мэдээлэл ирүүлэх, явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулж, Засгийн газарт танилцуулах гэж заасныг тус тус үндэслэл болгон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг танилцуулж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 8.5, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дахь хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ хийж Засгийн газрын хуралдаанд танилцуулан, холбогдох тайланг Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд тус тус хүргүүлнэ

гэж заасны дагуу 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Байнгын хороонд хүргүүлсэн болно.

Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Засгийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим систем, www.newunelgee.gov.mn-нд ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланд үндэслэн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.3-д заасан аргачлалыг баримталсан болно.

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилтийн тухайд Засгийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн санд Монгол Улсын 89, Улсын Их Хурлын 104, Улсын Их Хурлын Байнгын хорооны 79, нийт 272 шийдвэрийн 1550 заалт бүртгэлтэй байна.

Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрт хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилт нь 66.4 хувьтай байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй байгаа Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийг үнэлгээний ангиллаар авч үзэхэд 569 заалт буюу 36.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 390 буюу 25.2 хувь нь хэрэгжих шатандаа, 224 буюу 14.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 196 буюу 12.6 хувь нь хэрэгжээгүй гэж дүгнэгдсэн байна.

Харин хэрэгжилтийн тооцох хугацаа болоогүй үндэслэлээр 170 заалт үнэлэх боломжгүй байна. Хэрэгжилт нь дунджаар 66.4 хувь байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хэрэгжилт бүрэн хангагдсан цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, шийдвэр хүчингүй болсон зэрэг шалтгаанаар 519 заалтыг хяналтаас хасуулах саналтай байна.

Ингээд Байнгын хорооны гишүүд Та бүхэн Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлантай танилцана уу.

Ж.Бат-Эрдэнэ: Ийм товчхон байгаа билүү?

Тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Э.Болормаа гишүүн. Дээрээс нь би асууна. Ингээд 2 гишүүн. Э.Болормаа гишүүн.

Э.Болормаа: Ингээд өнөөдрийн энэ оруулж ирж байгаа асуудалтай холбоотойгоор ер нь Улсын Их Хурлаас гаргаж байгаа Байнгын хороодын тогтоол, Улсын Их Хурлын тогтоол, хууль журмууд дээр яг энэ хэрэгжихгүй байгаа шалтгаануудыг нь хэр нарийн судалж байгаа вэ? Би бүр онцгойлон хоёр шалтгаан асуух гэсэн юм.

Эхнийх нь, санхүүгийн үр дагавартай зүйлсүүдийг хааяа магадгүй тогтоолын явцад тэрийг нь дутуу тооцоолсон байна уу, эсвэл Засгийн газар дээр очоод хөрөнгө мөнгө байхгүй ээ гээд хэрэгжих боломжгүй гэсэн нэг хэсэг зүйлсүүд байдаг байх. Энэ ер нь одоо энэ хэрэгжихгүй байгаа зүйлсүүдийн ойролцоогоор хэд орчим хувь байна?

Тэгэхээр энэ дээр нийт эдийн засгийн тооцоолол, бид дараагийн магадгүй төсвийнхөө төлөвлөлт дээр өмнө баталсан зүйлсүүдээ хэрэгжүүлэхийн тулд ийм хэмжээний төсөв мөнгө гарах ёстой юм гэдэг ч юм уу, эдгээр төлөвлөлтийг ирэх жилийнхээ төсөвтөө бэлдээд хийх ёстой болов уу гэж харж байна.

Эхнийх нь энэ төсөв мөнгөтэй холбоотой.

Хоёр дахь нь, Засгийн газар дээр дагалдах журмыг нь гаргахгүй байгаагаас ч юм уу, энэ удсанаас болж удаж байгаа хэр их хууль тогтоомжийн заалтууд байна гэж асуумаар байна.

Би онцлоод жишээлбэл Малчны тухай хуульд өөрчлөлтүүд ороод малчдаа дэмжих бодлого гаргасан боловч нөгөө дагалдах журам нь байхгүйгээс болоод хэрэгжиж чадахгүй байгаа ийм нөхцөл байдал жишээлбэл энэ дээр хэрхэн уягдах вэ гэдгийг. Энэ хоёр зүйлийг асуух гэсэн юм.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? 7 номер. Өөрийгөө танилцуулаарай.

Д.Үүрийнтуяа: Эрхэм гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр хууль тогтоомж хэрэгжихгүй байгаа шалтгаанууд нь...

Ж.Бат-Эрдэнэ: Өөрийгөө танилцуулаарай. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын үнэлгээ мониторингийн газрын дарга Д.Үүрийнтуяа байна.

Хууль тогтоомж хэрэгжихгүй байгаа шалтгаанууд нь гэх юм бол зарим нь энэ хэрэгжилтээс хасах гэдэг нь цаг хугацааны хувьд хэрэгжээд зарим нь дууссан. Тухайн төсөл, арга хэмжээ нь хэрэгжээд дууссан. Зарим нь хэрэгжихгүй байгаа гэхээсээ илүү хэрэгжилт нь байгаа зарим заалтуудыг нь бид одоохондоо хэрэгжилт болоогүй гэдгээр 206 дугаар журмаараа үнэлсэн байгаа.

Яг энд бид хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг төсөвтэй нь уялдуулж тайлагнахаас илүү хариуцсан яам, хариуцсан чиглэлийнх нь газрууд бүгдээрээ тайлангаа ирүүлээд энэ тайлангийнх нь хэрэгжилт дээр нь бид үнэлгээ хийгээд оруулж ирж байгаа.

Тэгэхээр цаад талд нь бид төсөв нь тухайн байгууллагын гүйцэтгэлийн удирдлага, бусад үйл ажиллагаан дээр бас тайлагнагддаг байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: 6 номерын микрофон. Э.Одбаяр сайд.

Э.Одбаяр: Э.Болормаа гишүүний асуултад нэмэлт тайлбар хийх нь зүйтэй байх.

Мэдээж хэрэгжилт нь хангалтгүй байгаа заалтуудын тухай асуух шиг боллоо. Ер нь ихэнх хэрэгжилт нь хангалтгүй байгаа хууль тогтоомжийн биелэлтийн ард нь юу вэ гэхээр санхүүгийн шалтгаан, тэгээд төлөвлөгдөөгүй төсөв, нөөцөө буруу тооцсоноос үүдэж л асуудлууд хэрэгжилт нь хангалтгүй үлдэж байгаа.

Тэгээд энэ ер нь Их Хурлын харьяа байгууллагуудын, Их Хурлаас гаргаж байгаа, Байнгын хороодоос гаргаж байгаа шийдвэрүүд гэлтгүй төрийн бүх шатанд гаргаж байгаа шийдвэрүүдийг төлөвлөлт, төсөвлөлт, үнэлгээ, тайлагналтыг ил тод, нэг платформ дээр гаргаж ирж асуудлыг шийддэг, ярьдаг, төлөвлөдөг байх шаардлага үүсчэн байгаа.

Тэгээд тэр чиглэлээр бас энэ ДМ-ийг нэвтрүүлнэ гэдэг дээр ажлын хэсгүүд гаргаад Их Хурлынхаа холбогдох ажлын хэсэгтэйгээ хамтарч ажиллаад явж байгаа.

Тэгээд Ерөнхий сайдаас.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Э.Болормаа гишүүн тодруулъя.

Э.Болормаа: Сая Э.Одбаяр сайдын хэлснээр би таамаглахдаа ихэнх хэрэгжээгүй шалтгаан нь бол ер нь төсөв мөнгө гээд л хэлэх болов уу гэж бодож байна л даа.

Гэхдээ сая Д.Үүрийнтуяа даргын хэлснээр бид нэгдсэн тайлангуудыг нэгтгэж аваад л тэгээд л түүн дээр орхичхоод байна гэдэг нь зүгээр хангалтгүй юм уу гэж бодоод. Та хэд маань ч гэсэн цаашдын ажилдаа энэ тайлангууд чинь үр дүнтэй байхын тулд яагаад, үүнийг бид яаж засварлах вэ гэдэг зүйл дээр нь л санал хэлээд байгаа юм.

Тэгэхээр одоо ингээд төсвийн тооцоолол дутсанаас болж юм уу бид аягүй сайн санаад тогтоол гаргаад ч юм уу, хууль тогтоомж гаргаад хэрэгжихгүй байтал дараа нь тооцооллоо буруу хийсэн шүү дээ гэдэг аягүй харамсалтай байхгүй юу.

Тэгэхээр мэдээж Улсын Их Хурал бол бүх төсвийн тооцоолол хийх бид тийм институт нь бол биш. Бид бодлогоо тодорхойлж байгаа. Тэр явцад ч гэсэн зөвхөн Сангийн яам гэлтгүй танай байгууллага ч гэсэн энэ тооцооллоо гаргаж ирмээр байгаа байхгүй юу.

Энэ яг боломжтой юм уу, болохгүй юм уу гэдгийг.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: 6 номерын микрофон.

Э.Одбаяр: Тийм. Э.Болормаа гишүүний хэлж байгаатай санал нэг байна.

Засгийн газар дээр шийдвэр гараад Эдийн засгийн хөгжлийн сайд, Сангийн сайд миний бие ороод ажлын хэсэг гараад. Өөрөөр хэлбэл төсвийг төлөвлөлтөөс нь эхлээд саяын хэлдгээр гүйцэтгэл, тайлагналт хүртэл нь ерөөсөө нэг цонхны бодлогоор асуудалд ханддаг, үнэлдэг, тэгээд бодитой дүгнэдэг байя гэдэг дээрээ шийдэл гаргаад олон улсын тэр хяналт үнэлгээний цогц системийг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа.

Тэгээд энэ чиглэлээрээ маш яаралтай арга хэмжээ авахгүй бол дараа дараагийн жилүүдэд бас ийм хүндрэлүүд гарахаар. Тэгээд тайлагналт бас бодитой бус байх ийм нөхцөл байдал үүсээд байгаа.

Хуулиараа яах вэ гэхээр бид хяналт хэрэгжүүлэх газрын хувьд цахим мэдээллийн санд ирүүлсэн тайланг л үнэлж үндэслэж үнэлгээ хийж байгаа. Яг газар дээрх хяналт шалгалтыг Үндэсний аудитын газар хийгээд тайлагнаад явдаг ийм ялгаатай байгаа.

Тэгээд энэ чиглэлээр тайлагналтын системээ нэгтгэх шаардлага.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Малчны тухай хуультай холбоотой асуулт асуусан. Тэр дээр хэн хариулах вэ? Малчны тухай хуульд заасан заалтууд хэрэгжээгүй юм байна. Тийм ээ. Түүнтэй холбоотой. Хариулах хүн алга уу? Хариулах хүн алга.

Э.Болормаа гишүүн хариулах хүн байхгүй байна шүү.

Би нэг ганц хоёр асуулт асуумаар байх юм. Ингэсэн шүү. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль өөрчлөлт ороод Улсын Их Хурлаас өгсөн үүрэг даалгавар, өөрөөр хэлбэл хуульд чиглэл өгсөн тийм үү, чиглэл өгсөн,

хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг гаргаж өгнө гээд. Засгийн газар.

Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлаас Засгийн газар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө гаргаж өгнө гэж байгаа юм.

Тэгээд өнөөдөр Э.Одбаяр сайд маань ганцаараа л хүрч ирээд хяналт шалгалт хийсэн гэсэн утгаараа гаргаж ирж байх шиг байна. Яг одоо бид яг ямар чиглэлээр үүрэг даалгавар өгсөн. Одоо энэ дээр таны хэлснээр 66.3 хувь нь биелсэн гэж байна шүү дээ. Тийм үү? Цаана нь 36 хувь нь биелээгүй гэсэн үг. Тийм үү?

Тэгэхээр энэ болгон дээр Та хариулт хэлж чадах уу? Жишээ нь, 2023 оных байх аа. Би сайн хэлж мэдэхгүй байна. Цаг хугацааг нь. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос малын халдварт өвчинтэй тэмцэх тухай гэдэг байх аа.

Би бас юуг нь сайн тодорхой хэлж чадахгүй байна. Тэмцэх тухай тогтоолын Засгийн газарт үүрэг болгосон Байнгын хорооны тогтоол байх ёстой.

Энэ ерөөсөө хэрэгжээгүй. 7, 8 заалттай байх ёстой. Жишээ нь, энэ дээр хариулт хэлж чадах уу? Яагаад хэрэгжээгүй юм?

Хоёрдугаарт, саяын 34 хувь нь хэрэгжээгүй байгаа тогтоолууд, үүрэг даалгавар болгосон ийм тогтоолууд Засгийн газар дээр хэрэгжээгүй гэж байна шүү дээ.

Тэгвэл энэ чинь Улсын Их Хурлын Байнгын хороод тогтоол, шийдвэр гаргаад Засгийн газарт үүрэг, чиглэл болох ямар хэрэг байгаа юм? Энэ дээр нэг хариулт өгөөч. 6 номерын микрофон. 7 номерын микрофон.

Д.Үүрийнтуяа: Энэ чиглэл өгөх тухай Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоол байна.

Тэгээд 2020 оны 12 сарын 16-наас гээд тайлагналтууд нь гарсан байна. Зарим арга хэмжээ нь 3 арга хэмжээ 100 хувьтай дүгнэгдсэн, 1 арга хэмжээ 30 хувьтай үнэлэгдсэн байна.

Тэгэхээр заалт болгоноор нь танд уншиж явах уу, танилцуулаад явах уу?

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2020 оны 07 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосугай гэсэн байна.

Мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжих, мах, махан бүтээгдэхүүнийг экспортолдог аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх гэсэн байна.

Энэ дээр тухайн байгууллага тайлагнахдаа заалтын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам тайлагнасан.

Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны ажлын алба, Баянхонгор аймгаас бусад 20 аймгийн Засаг даргын Тамгын газраас тайлангуудыг ирүүлсэн байна.

Ирүүлсэн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд тус заалтын хэрэгжилт нь дараах аймгуудад бүрэн хангагдаагүй. Тэгээд хангагдсан, хангагдаагүй гээд нийтэд нь үнэлээд ерөнхийдөө энэ арга хэмжээг 70 хувьтай гэж үнэлсэн байна.

Одоо хэрэгжих шатдаа явж байгаа гэж дүгнэгдсэн.

Дараагийнх нь, мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийн мах бэлтгэлийн үед бага хүүтэй, урт хугацаатай зээлийн эх үүсвэрээр дэмжих гэсэн байна.

Үүнийг хүнсний боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад эргэлтийн хөрөнгөөр дэмжих, мах бэлтгэхэд зориулсан эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн дэмжлэг, зээл жилийн нийтдээ 6 хувийн зээлдэгчээс Засгийн газраас хариуцаж төлөх 13 хувийн хүүтэй гээд. Ингээд нийтдээ 12 сарын хугацаатайгаар тусгагдаж өгсөн ийм арга хэмжээ байсан байна.

2024 оны 12 сарын байдлаар 18 аж ахуйн нэгжид нийтдээ 41.2 тэрбум төгрөгийг олгосон байна.

Энэ арга хэмжээ нь 100 хувьтай үнэлэгдсэн байна.

Дараагийнх нь мах, махан бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулалтын...

Ж.Бат-Эрдэнэ: Наад чинь биш байна. Малын эрүүл мэндтэй холбоотой заалттай байгаа.

Наадах чинь 2020 оных юм байна. Би санахдаа 2022, 2023 хавьцаа л байсан санагдаад байх юм. 2022 он ч юм уу.

Ингэвэл яасан юм бэ? Одоо зөвхөн наадах чинь хяналт шалгалтын тайлан байна. Яг ямар заалт яагаад хэрэгжээгүй гэдгийг салбарын сайдтайгаа, ядаж Н.Учрал сайдад чинь хүрч ирж танилцуулбал яасан юм бэ.

Би бол одоо буцаачихмаар байна. Тэгж байж Улсын Их Хурал өөрийнхөө гаргасан, өөрийнхөө чиглэл өгсөн хууль, тогтоолын дүрэм, журам, биелэлт дээр хяналт тавих ёстой байхгүй юу даа.

Бид эндээс хуралдаад л Засгийн газарт чиглэл өгөөд л байдаг. Тэгээд чиглэл нь 66 хувьтай орж ирээд байх юм бол ямар хэрэг байсан юм. Тэгээд тэрийг нь зөвхөн та хянасан гэж орж ирээд, цаана нь яг ямар хөдөө аж ахуй дээр, байгаль орчин дээр, дэд бүтэц дээр бүхий л асуудлууд чинь шийдэгдэхгүй байгаад байхад тэгээд зүгээр нэг тайлан уншаад гараад явж болохгүй шүү дээ.

Юу яая. Ж.Баярмаа гишүүн асуулт асууя. Ж.Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Кноп дарсан л даа. Тэгээд тэр бүр бас ажиллахгүй байна. Нэгд.

Хоёрт, ер нь бас асуулт асууж ер нь болох юм болов уу? Ж.Бат-Эрдэнэ дарга асуулт ер нь асууж болох уу? Тийм.

Ж.Бат-Эрдэнэ: Би асуулт асуух цагийг чинь өгөөд өөрөө хоцорч ирсэн үү, яаав. Тийм болохоор дахиад нэмэлт цаг, нээлттэйгээр өөрийг чинь асуулт асуух бололцоог олгож байна.

Ж.Баярмаа: Ер нь засгийг төлөөлж байгаа учраас засгаас ер нь асуулт асууж болох эсэхээ сайн мэдэхгүй байна. Тэгэхдээ яах вэ нэгэнт Байнгын хорооны дарга эрх олгосон учраас асууя.

Түүнээс биш энэ чинь асуулт асууснаасаа болж асуудалд ороод байгаа учраас. Энд нэг ийм юм байна шүү дээ.

Нийт шийдвэрийн биелэлтийн дундаж 53.9 хувь гээд. Тийм ээ. Тэгэнгүүтээ энэ арын хуудсан дээр биелэлтийг тайлагнаагүй шийдвэрүүдийг хэрэгжээгүй гэж тооцох юм бол нийт шийдвэрийн дундаж хоёр дахин буурч байна. Өөрөөр хэлбэл огт тайлагнаагүй асар олон зүйл байна гэж үзсэн байна шүү дээ. Тэгээд тэрийг нь хэрэгжээгүй гээд тооцох юм бол 25 хувьтай байна гэж байна шүү дээ.

Тэгэхээр Улсын Их Хурлаас зөндөө хууль, тогтоол гаргаад байдаг. Тэгээд хэрэгжилт нь ерөөсөө 25-хан хувьтай байна гэдэг чинь одоо яг юу гэсэн үг юм болоо.

Энэ тэгээд дандаа Засгийн газрын хэрэгжүүлэх ажлууд уу? Эсвэл Улсын Их Хурлын харьяа байгууллагуудын хэрэгжүүлэх ёстой ажлууд холилдоод явж байгаа юм болов уу?

Тэгэхээр 25 хувьтай байна гэдэг чинь одоо бүр “F”-ийн “F” шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр үүнийг одоо ер юу гэж дүгнэх юм бэ энэ чинь? Засгийн газар чинь Үндсэн хуулиараа хуулийн хэрэгжилтийг нь хангах институц. Танай яам бол яах вэ? Энэ хэрхэн хэрэгжсэнийг л зүгээр үнэлгээ өгч байгаа байгууллага.

Тэгэхээр яг хэрэгжүүлэх шатдаа ямар алдаа гараад, яагаад хэрэгжихгүй байсан юм бэ гэдгийг чинь яг сая Ж.Бат-Эрдэнэ даргын асуусанчлан тэр Ерөнхий сайд нь ч байдаг юм уу, Хэрэг эрхлэх газрынх нь дарга л хариуцах ёстой байх л даа. Яагаад хэрэгжээгүй юм?

Яагаад 25-хан хувьтай байгаа юм бэ? 100 хувиас шүү дээ гэдэг ийм асуулт асууж байна. Тэгээд энэ 25 хувь дотор ганцхан засгийн ажил орж байна уу, эсвэл Улсын Их Хурал ч гэсэн өөрийнхөө харьяа байгууллагын ажил орж байна уу гэдгийг асууя.

Ж.Бат-Эрдэнэ: 6 номерын микрофон. Э.Одбаяр сайд хариулъя.

Э.Одбаяр: Улсын Их Хурлын эрхэм гишүүн Жудагийн Баярмаагийн асуултад хариулъя.

Өнөөдрийн оруулж байгаа тайлан бол юу вэ гэхээр Засгийн газар дахь хяналтын тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Засгийн газар луу өгсөн Байнгын хорооны шийдвэр, Их Хурлын тогтоол, хуулиудын тайлан.

Үүнээс гадна Их Хурлын харьяа байгууллагуудын тайлан бас орох ёстой.

Тэгээд таны асууж байгаа 25.6 хувь буюу 2 дахин буурч байна гэдэг дүгнэлтийг Их Хурлын Тамгын газар луу Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас, Засгаас гэсэн үг. Энэ тайланг ирүүлсэн дээр үнэлгээ хийгээд 25.6 хувийн 2 дахин буурч байна гэдэг дүгнэлтийг хийсэн байна.

Тэгэхээр энэ тоог Тамгын газраас ингэж дүгнэсэн учраас яагаад ингэж багасгаж дүгнэсэн бэ гэдэг дээр Улсын Их Хурлын Тамгын газраас асуувал дүгнэлт, тоо хийсэн хүмүүс хариулт өгөх байх гэж ойлгож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Асуулт асууж дууслаа. Ж.Баярмаа гишүүн сая буруу ойлгочихсон уу, яасан.

Би уг нь нээлттэй Танд юу өгөөд байгаа шүү дээ? Асуух асуулт өгөөд байгаа шүү дээ. Тийм. Өөр тийшээ ярьсан хариулт байсан юм шиг байна.

Улсын Их Хурлаас оруулж ирсэн үүрэг даалгавар, чиглэл болгосон ажлууд маань 66 хувьтай юм байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Э.Одбаяр сайдын хувьд ерөнхий тайлангаа гаргаад тавьж байна. Үүний цаад салбарын сайд нараас тухайн Байнгын хороодоос өгсөн үүрэг даалгавар, Байнгын хороодоос өгсөн чиглэлүүд ер нь яаж хэрэгжсэн юм. Зарим нь яагаад хэрэгжээгүй юм гэдэг дээр тодорхой хариулт авъя. Тийм болохоор асуудлыг хойшлууллаа.

Дараагийн удаа тодорхой сайд нартайгаа, ядаж Н.Учрал сайд хүрч ирж салбар салбараа төлөөлсөн ийм төлөөлөлтэйгөө хүрч ирж гишүүдийн асуултад хариулъя гэсэн бодолтой байна. Тийм болохоор асуудлыг хойшлууллаа.

Дараагийн хуралдаан дээр үргэлжлүүлж сонсьё. /алх цохив/

Ингээд Байнгын хорооны хуралдаан дууссан тул гишүүдэд баярлалаа. Байнгын хорооны хурал дууслаа. /алх цохив/

Хуралдаан 40 минут үргэлжилж, 15 цаг 38 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД